



468  
ГМОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД  
ЖАРГАЛТУЛГЫН ЭРДЭНЭБАТ  
ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ  
АСУУЛГА

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
Их эзэн Чингис хааны нэрэмжит талбай 1,  
Төрийн ордон, Утас: 26-70-16, Факс: 32-70-16  
E-mail: stategreathural@parliament.mn  
<http://www.parliament.mn>

2017.02.21 № 03

Г Асуулга тавих тухай

Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хуулийн хэрэгжилтийн явцад хууль, эрх зүйн орчныг сайжруулах, төсвийн орлогыг нэмэгдүүлэх, төсвийн зардлыг хэмнэх, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компаниудын менежментийг сайжруулах асуудлын хүрээнд Монгол Улсын Засгийн газраас авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.13, 33 дугаар зүйлийн 33.1.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн Монгол Улсын Ерөнхий сайд Танд дараах асуулгыг тавьж байна.

1.“Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 2016 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн тогтоолын биелэлт, уг тогтоолын хүрээнд авч хэрэгжүүлсэн болон хэрэгжүүлэх арга хэмжээний талаар;

2.Уг тогтоолын хүрээнд татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийг багасгах болон хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, түүний эрх зүйн орчинг боловсронгуй болгох талаар;

3.Төсвийн зардлыг хэмнэх асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ болон цаашид хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа бодлогын талаар;

4.Төр өмчит болон төрийн өмчийн оролцоотой компаниудын үйл ажиллагааг сайжруулах хүрээнд хэрэгжүүлж байгаа бодлого болон цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар.

Асуулгын хариуг Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.3-т заасан хугацаанд бичгээр ирүүлж, Монгол Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэхийг Танаас хүсье.

УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ГИШҮҮН



Л.БОЛД